

НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ
ТЭМЦЭХ ГАЗАР



2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
БҮТЭН ЖИЛИЙН ТАЙЛАН

/2022.12.27/

АГУУЛГА

<p>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хэмжээний хэрэгжилт Нийслэлийг хөгжүүлэх 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт</p>	<p align="center">3</p>
<p>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН Улсын Их Хурал болон Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт Засгийн газрын тогтоолын хэрэгжилт, Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигийн хэрэгжилт Ерөнхий сайдын захирамжийн хэрэгжилт Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт Нийслэлийн Засаг даргаас зарласан зорилтот ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил</p>	<p align="center">4</p>
<p>ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН Дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилт Хүний нөөцийн чадавхижуулалт, нийгмийн баталгаа Архив, албан хэрэг хөтлөлт Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа Төсөв, санхүү, орлого бүрдүүлэлт “Нийслэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д гаргасан тайлан мэдээ</p>	<p align="center">5-56</p>
<p>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ Үйл ажиллагааны ил тод байдал Хүний нөөцийн ил тод байдал</p>	<p align="center">57-59</p>
<p>ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ Холбогдох чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагуудтай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны талаар Дотоод хяналт шинжилгээ үнэлгээний талаар Байгууллагын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтын талаар Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар</p>	<p align="center">60-73</p>

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар нь тайлант хугацаанд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан “Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр”, Агаарын тухай хууль, МУ-ын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол болон бусад холбогдох хууль, тогтоомжийг мөрдүүлэх замаар агаарын бохирдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар:

- Алсын хараа -2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 1 зорилтын 3 арга хэмжээний хэрэгжилт
- ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2 зорилт бүхий 2 арга хэмжээний 2 заалтын хэрэгжилт
- Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2 зорилт 2 арга хэмжээний хэрэгжилтийг тус тус нэгтгэн НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлсэн.
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 зорилт 12 арга хэмжээний биелэлтийг
- Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний 14 зорилт 14 арга хэмжээний хэрэгжилт
- Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1 зорилт бүхий 2 арга хэмжээний 6 заалтын хэрэгжилтийг нэгтгэн 2022 оны 1 болон 2, 3, 4 дүгээр улирлын байдлаар гарган НЗДТГ-т албан бичгээр хүргүүлсэн.

Байгууллагын бодлогын зорилтуудын хэрэгжилтийн тайланг бүтэн жилээр нэгтгэн гаргаж хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг Газрын даргын зөвлөлийн хурлаар улирал тутам хэлэлцүүлж хэвшсэн ба биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдэд тухай бүр тайлагнаж ажиллав.

- Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврыг өөрийн байгууллагад холбогдох заалтуудыг хяналтад бүрэн авч карт хөтөлж ажилласан. 2022 оны байдлаар 12 шийдвэрийн 18 заалтын хэрэгжилтийг гаргаж ажилласан.
- Нийслэлийн онцгой комиссын 8 дугаар хурлын тэмдэглэл <http://monitoring.ub.gov.mn> цахим хуудсанд оруулж тайлагнасан.
- Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 01-04, 01-06, 01-06а, 02-03, 02-04 дугаар хурлын тэмдэглэлийн хэрэгжилтийг гарган цаасаар болон <http://monitoring.ub.gov.mn> цахим хуудсанд оруулж тайлагнасан.
- Байгууллагын дүрмийн биелэлтийг гаргаж хүргүүлэв.
- Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн өгсөн 24 удаагийн үүрэг даалгаврын хэрэгжилтийг цаасаар болон <http://monitoring.ub.gov.mn> цахим хуудсанд оруулж тайлагнасан.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

а). Байгууллагын хэмжээнд хэрэгжиж байгаа Монгол Улсын Их хурлын тогтоолын 2 шийдвэрийн 3 заалт, УИХ-ын Байнгын хорооны тогтоолын 1 шийдвэрийн 2 заалт, Ерөнхийлөгчийн зарлигийн 1 шийдвэрийн 2 заалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж 1 шийдвэрийн 2 заалт, Засгийн газрын тогтоолын 2 шийдвэрийн 6 заалт, Ерөнхий сайдын захирамж 1 шийдвэрийн 2 заалт, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 4

шийдвэрийн 14 заалт, Засгийн газрын 1 албан даалгаврын 3 заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн тогтоолын 1 шийдвэрийн 1 заалтыг тус тус хяналтад авч хэрэгжилтийн хувийг тооцон хагас жилийн байдлаар гарган даргын дэргэдэх хурлаар хэлэлцүүлэн танилцуулгын хамт НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлсэн.

б) Нийслэлийн Засаг даргаас тухайн жилд хэрэгжүүлэхээр зарласан зорилтот ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн өгсөн 24 үүрэг даалгаврын 110 заалтын биелэлтийг цаг тухайд нь гаргаж НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ulaanbaatar.mn сайтад байршуулсан.

- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хооронд байгуулсан байгаль орчин, аялал жуулчлалын салбарт 2022 онд хамтран ажиллах гэрээнд туссан 6 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан биелэлт
- Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Хотын иргэний жил” а/01 дүгээр захирамжийн төлөвлөгөөний биелэлт
- Албан хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх ажлын төлөвлөгөөний 2022 оны биелэлтийг гаргаж Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлсэн.
- Авлигатай тэмцэх газрын төлөвлөгөөний биелэлт
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хорооны хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд гаргаж хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 360 дугаар тогтоолоор байгууллагын нэршил “Агаар, орчны бохирдолтой тэмцэх” газар гэж НЗД-ын А/1037 дугаар захирамжаар өөрчлөгдсөнтэй холбогдуулан нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/164 дүгээр захирамжаар “Байгууллагын дүрэм”-ийг шинэчлэн батлуулсан болно

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтэц, тэдгээрийн орон тооны хязгаарыг батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 360 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1059 дүгээр захирамжаар байгууллагын орон тооны хязгаарыг 40 хүртэл байхаар тогтоосон.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

3.1 Мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, чирэгдэлгүй хүргэдэг ухаалаг хотыг бий болгох ажлын хүрээнд:


Тайлант хугацаанд Архивын Ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, Стандартчилал Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2008 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Цахим баримт бичгийн солилцоо” стандарт /MNS ISO17933:2008/, 2011 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт” /MNS 5140-1:2011, MNS5140-2:2011, MNS 5140-3:2011/-ын хэрэгжилтийг хангаж, индексийг 100 хувиар биелүүлэн ажилласан.

3.2 Агаарын бохирдлын хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх хор уршиг, түүнийг бууруулах, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/346 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил болон Агаар, орчны бохирдлыг бууруулах асуудал хариуцсан орлогчийн 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдөр баталсан “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлээс хамгаалах ажлын удирдамж”-ийн хүрээнд 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийн хооронд нийслэлийн 7 дүүргийн хэмжээнд Угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх дараах арга хэмжээг зохион байгуулж, ажилласан. Үүнд:

- Угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх 160,000 ширхэг зөвлөмжийг гэр хорооллын айл өрхүүдэд хүргэсэн.
- Дүүргүүдийн хог тээвэрлэгч аж ахуйн нэгжийн машин механизмаар сэрэмжлүүлэх дуут зөвлөмжийг бэлтгэн хүргүүлсэн.
- Угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх шторкыг байгууллагын www.aprd.ub.gov.mn цахим хуудас, Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар, Нийслэлийн мэдээ фэйсбүүкийн цахим хуудас, хамтран ажилладаг 7 сайт, Ийгл телевизээр өдрийн 6 удаагийн давтамжтай 11:00, 13:00, 15:00, 17:00, 19:00, 21:00 цагийн мэдээний араас 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл нэвтрүүлж олон нийтэд хүргэсэн.

Зураг №1.



Угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх шторк

➤ Зөвлөмж сэрэмжлүүлэг бүхий 20 цуврал постерыг дүүрэг, хороодын цахим хуудас болон байгууллагын албан ёсны вэбсайт <https://aprd.ub.gov.mn/>, Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар фэйсбүүкийн цахим хуудсаар дамжуулж нийт давхардсан тоогоор 49000 хүнд хүргэж ажилласан.


Зураг №2



Угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх постер

➤ Агаарын бохирдлын хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх хор уршиг, түүнийг бууруулах, мод тарих ач холбогдолын талаар олон нийтэд чиглэсэн 6 ширхэг видео контентыг байгууллагын албан ёсны вэбсайт <http://www.aprd.ub.gov.mn/>, фэйсбүүкийн цахим хуудас Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар, Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар, Нийслэлийн мэдээ фэйсбүүкийн пэйж хуудас хамтран ажилладаг 5 цахим хуудсаар дамжуулан давхардсан тоогоор 55.000 хүнд хүргэж ажилласан.

Зураг №3



Угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээллийг сайтуудаар иргэд, олон нийтэд хүргэж буй байдал



➤ Тайлант хугацаанд Ийгл, MNB, Тв9, UBS телевизээр гэр, байшинг дулаалах, агаарын бохирдлыг бууруулахад хийж хэрэгжүүлж буй ажил, агаарын чанарын талаар нийт 10 ярилцлага, мэдээллийн хөтөлбөрт албан хаагчдыг оролцуулсан. Мөн <https://ulaanbaatar.mn/>, <https://www.polit.mn/a/96307>, <https://ikon.mn/n/2n7h>, <http://www.shuud.mn/a/544270> зэрэг 10 сайтаар олон нийтэд хийж хэрэгжүүлж буй ажлын талаар, зөвлөмж сэрэмжүүлэг, мэдээллийг хүргэсэн. Үүнд:

- Угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх А/346 дугаар захирамжийн хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын талаар БХХ-ийн дарга <https://ulaanbaatar.mn/> вэбсайтад, авто машинаас үүдэлтэй агаарын бохирдлын асуудлаар АЧХЗБХ-ийн дарга ТВ-9 телевизэд, ойн хээрийн түймрээс үүдэлтэй агаарын бохирдлын талаар АЧХЗБХ-ийн мэргэжилтэн нарыг оролцуулж мэдээлэл өгсөн.

Мөн гэр, байшинг дулаалах талаар АЧХЗБХ-ийн дарга Монголын үндэсний радио телевизэд <https://ulaanbaatar.mn/>, сайжруулсан шахмал түлшний нөөцлөлт, тээвэрлэлт, борлуулалтын цэгийн мэдээллийг Газрын дарга <https://www.polit.mn/a/96307>, <https://ikon.mn/n/2n7h>, <http://www.shuud.mn/a/544270>, монголын үндэсний телевизийн “Нээлттэй хором” шууд хэлэлцүүлэгт агаарын бохирдлыг бууруулахад хийж хэрэгжүүлж буй ажлын талаар Газрын дарга, АЧХЗБХ-ийн дарга нар, тв 9 телевизийн “Энэ өдөр” мэдээллийн хөтөлбөрт агаарын чанарын асуудлаар газрын дарга, АЧХЗБХ-ийн дарга нар мэдээлэл өгсөн

Зураг №4



Нэвтрүүлэг, сайтад ярилцлага, мэдээлэл хүргэсэн нь

3.3 Мэдээлэл технологийн ажлын хүрээнд:


➤ Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу Нийслэлийн ЗДТГ-ын хэвлэл мэдээлэлтэй харицах хэлтсийн <https://www.ulaanbaatar.mn/>, “Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар”-ын албан ёсны цахим хуудас <http://aprd.ub.gov.mn/>, болон Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар фэйсбүүкийн цахим хуудас, хамтран ажилладаг 14 сайт, 2 телевиз, Өглөөний сонингоор байгууллагын үндсэн үйл ажиллагаа, бодлого, удирдлагуудын шийдвэр, хийж буй ажлын талаарх мэдээ мэдээллийг тогтмол шинэчлэн түгээж, олон нийтэд үнэн бодитоор, шуурхай хүргэх ажлыг зохион байгуулан, иргэдийн мэдээлэл авах эрхийг ханган ажиллаж байна.

Тус тайлант хугацаанд нийт 54 мэдээ бэлтгэн нийтэлсэн бөгөөд байгууллагаас хийгдсэн хэмжилт, хийж хэрэгжүүлсэн ажлын талаар 23, сайжруулсан түлшний борлуулалтын цэг, түгээлтийн талаар 8, угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж 7, Монгол Улсын шадар сайдын 2021 оны “Усан халаалтын болон уурын зуухыг дэвшилтэд технологид шилжүүлэх тухай” 123 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах талаар 4, бусад 12 төрлийн мэдээ, мэдээллийг бэлтгэн олон нийтэд хүргэж ажилласан. Байгууллагын ил тод байдал, байгууллагаас хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагааг олон нийтэд хүргэж ажилласан. Тайлант хугацаанд байгууллагатай холбоотой буруу ташаа мэдээлэл гараагүй болно.

➤ Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хуучнаар Нийслэлийн мэдээлэл технологийн газартай хамтран вирусны программын лицензийн хугацааг сунгах шаардлагатай 30 компьютерт вирусны программ суулгасан.

➤ Байгууллагын <https://aprd.ub.gov.mn/> вэбсайт, болон мэдээллийн самбарын мэдээллийг тухай бүр шинэчлэн ажилласан.

Зураг №5.



Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын албан ёсны сайт <http://aprd.ub.gov.mn/> болон Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар фэйсбүүкийн цахим хуудсаар мэдээлэл тавигдсан байдал

3.4 Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах зарим арга хэмжээний тухай” А/1025 дугаар захирамжийн хүрээнд:

Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах зарим арга хэмжээний тухай” А/1025 дугаар захирамжаар “Шуурхай штаб”-ыг байгуулан 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн “Таван толгой түлш ХХК-ийн Хэрэглэгчдэд үйлчлэх албаны хяналтын нэгдсэн төвийн байранд харьяа мэргэжлийн байгууллагын албан хаагчид тодорхой хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэн ажилласан байна. Шуурхай штабын байранд “Таван толгой түлш” ХХК-тай хамтран 70119400 гэсэн 1-р шугамаар, дүүргүүдийн шуурхай дэд ажлын хэсгийн мэдээ, дуудлагыг хүлээн авч, тайланг Шуурхай штабын удирдах багт тогтмол мэдээллэн ажиллаж байна.

Зураг №6



Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны даргын баталсан удирдамжийн дагуу “Яндангаа хөөлье-Өнтэй өвөлжье” аяны хүрээнд 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах, мэдээлэл, заавар зөвлөгөө өгөх сургалтыг 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр Засаг захиргааны 5 дугаар байранд Нийслэлийн 7 дүүргийн хороодын засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарын 250 гаруй албан хаагч нарт гэр хорооллын айл өрхүүдийн иргэдэд стандартын шаардлага хангасан зуух хэрэглэх, угаарын хийн мэдрэгч төхөөрөмжийн ашиглалтын заавар, сайжруулсан түлшний зөв галлагааны талаарх зөвлөмж, угаарын хийн эрсдэлд өртсөн тохиолдолд үзүүлэх анхан шатны тусламж, мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх зэрэг сургалтыг зохион байгуулсан. Мөн гэр хорооллын айл өрхийн ханан пийшин, зуухны бүрэн бүтэн байдлыг хангах, агааржуулалтын системийг сайжруулах, битүүмжлэлийг шалгах, яндан хөөлөх, зөв галлагааны зааварчилгаа өгөх, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах сургалт семинарыг 5 удаа зохион байгуулж, видео шторк, зурагт хуудас /постер/, баннерыг байгууллагын цахим хуудас, вэбсайт болон хамтран ажилладаг вэбсайт, Нийслэлийн мэдээ, телевизүүдэд байршуулан иргэд олон нийтэд тогтмол хүргэн ажиллаж байна.

3.5 Гэр, байр, орон сууцны доторх агаарын бохирдлыг бууруулах, арилгахад чиглэсэн зөвлөмж гаргаж, олон нийтэд сурталчилна.

Нийгмийн Эрүүл мэндийн Үндэсний төвийн ерөнхий захирлын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/34 дүгээр тушаалаар “Дотоод орчны агаарын чанарын стандарт боловсруулах ажлын хэсэг байгуулах” тухай тушаал батлагдсан. Тус ажлын хэсэг нь “Дотоод

орчны агаарын чанарын стандартын төсөл”-ийг хэлэлцүүлж, төсөлд оруулах саналыг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. Дотоод орчны агаарын чанарыг сайжруулах чиглэлээр 3 төрлийн постер бэлтгэн иргэд олон нийтэд хүргэн ажилласан.

Зураг №7



3.6 Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх ажлын хүрээнд:

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-аас техникийн туслалцаагаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран хэрэгжүүлж байгаа “Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл” (3-р үе шат)-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.

Улаанбаатар хотын агаар бохирдуулах эх үүсвэрүүдэд хяналт тавих чадавхыг бэхжүүлэх замаар агаарын бохирдлыг бууруулах тогтолцоог нийслэлийн нутгийн захиргааны холбогдох байгууллагуудад бий болгох, хамтрагч талын оролцоог хангах, агаар орчны хяналт шинжилгээний тогтолцоог бүрдүүлэх, агаар бохирдуулагч гол эх үүсвэрийг тодорхойлох, зуухны бүртгэл, хяналтын тогтолцоог нэвтрүүлэх, сайн чанарын сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлт, утааны хийн шаталтын хэмжилт болон үр дүнг баталгаажуулах туршилт зэрэг томоохон ажлуудыг хэрэгжүүлж, боловсон хүчний чадавхыг дээшлүүлэхэд онцгой анхаарч ажиллаж байна.

Автомашинд суурилуулдаг хаягдал утаа хэмжигч (АСХУХ) үр дүн боловсруулах сургалтын дагуу хамгийн эхний хэмжилтийн дүнг боловсруулан гаргасан. Хэмжилтэд дизель хөдөлгүүрт нэг тээврийн хэрэгсэл ашигласан бөгөөд Хэмжилтийн дүнгээр автомашин хөдөлгөөнд жигд хурдтай оролцох үед ялгарах Хүхрийн давхар исэл (SO₂), Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) хэмжээ ялгарал бага байсан бол хурд ихтэй болон удаан оролцож байх үед ялгарал ихсэж Хүхрийн давхар исэл (SO₂), Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) ихээр ялгарч байгаа үзүүлэлттэй байсан.

3.7 Агаарын чанарын улсын хяналт-шинжилгээний сүлжээний нэгжийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, хүрээлэн буй орчинд мониторинг хийх чиг үүргийн хүрээнд:

Агаарын чанарын суурин харуулуудийн мэдээг 7 хоног, сараар боловсруулан гарган Ус цаг уур орчны шинжилгээний газарт хүргүүлэн ажиллаж байна.

Зураг №8




2022 онд нэг суурин харуул дээр дунджаар 50 удаа очиж засвар үйлчилгээ, хяналт хийж ажилласан. Суурин харуул тус бүрээр авч үзэхэд Баянхошуу суурин харуул дээр 49, Толгойт суурин харуул дээр 45, Нисэх суурин харуул дээр 51, Амгалан суурин харуул дээр 48, МҮОНРТ суурин харуул дээр 55 удаа тус тус очиж ажилласан байна.

Тус харуулуудаар очиж ажиллахдаа хэмжилтийн хэвийн үйл ажиллагааг хангах багажнуудын тоосны фильтр солих шугам хоолойн цэвэрлэгээ хийх хэмжилт тасарсан тохиолдолд дахин ачааллуулах зэргээр ажилласан.

Толгойтын суурин харуулын APSA-370 хэмжилтийн багаж төхөөрөмжийг Япон болон Герман улс дахь үйлдвэрлэгчийн газар руу илгээж, засварлуулан авчирч суурилуулсан. Баянхошуу суурин харуулын тоосонцор хэмжих APDA-371 хэмжилтийн тоног төхөөрөмжийг Япон улс руу үйлдвэрлэгчийн газар руу илгээж, засварлуулан авчирч суурилуулсан.

Зураг №9



2022 оны Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтсийн дарга суурин харуул тус бүр дээрх Озоны багажуудыг ЦУОШГ-ийн харьяа БОХЗТЛаборатори дээр хийн тохируулга, цэвэрлэгээ хийх, мөн суурин харуулуудын бусад багажид стандарт хийн тохиргоо хийж хэмжилтийн баталгаажуулах үүрэг өгсний дагуу Толгойт, Нисэх, Амгалан, МҮОНРТ суурин харуулуудад хийн тохируулга хийж ажилласан.



Суурин харуулын өвлийн бэлтгэл ажил хангах, хэмжилтийн тасралтгүй ажиллагааг хангуулах хүрээнд суурин харуулын сэлбэг хэрэгсэл худалдан авах тендерт шалгарсан “Интерсайнс” ХХК-тай гэрээ байгуулан сэлбэг хэрэгсэл солих нөөцлөх ажлыг зохион байгуулж ажилласан.

Суурин харуулын хэмжилтийн баталгаажилтыг хангуулах зорилгоор стандарт хийн худалдан авалтийн тендерт шалгарсан “Универсал инженеринг” ХХК-тай 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр 03/03 тоот гэрээ байгуулан стандарт хий худалдан авах шатандаа явагдаж байна.

Суурин харуулын хэмжилтийн ажилласан нийт цаг 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс 2022 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар МҮОНРТ-85,9%, Нисэх-80,5%, Толгойт-64%, Амгалан-89,9%, Баянхошуу-85% байна. Суурин харуулуудын нийт дундаж хэмжилтийн цаг 81%-ийн гүйцэтгэлтэй байна.

Суурин харуулуудын хэмжилт тасарсан нь тог цахилгааны гэмтэл, цахилгааны ачаалалтай үед автомат унах, цахилгааны төлөвлөгөөт засвар үйлчилгээ зэрэг шалтгаанаас суурин харуулын мэдээ тасарсан байна.

2022/01/01-2022/11/30 хүртэл ажилласан цаг										
Хэмжилтийн төрөлүүд	МҮОНРТ		Нисэх		Толгойт		Амгалан		Баянхошуу	
	Хэмжих цаг		Хэмжих цаг		Хэмжих цаг		Хэмжих цаг		Хэмжих цаг	
	8016	Хувь	8016	Хувь	8016	Хувь	8016	Хувь	8016	Хувь
	Хэмжсэн цаг		Хэмжсэн цаг		Хэмжсэн цаг		Хэмжсэн цаг		Хэмжсэн цаг	
NOx	6954.0	87.7	6633	82.7	4467.0	55.7	6680	83.3		
CO	6828.0	85.0	6386	80.0	3532.0	44.0	6915.0	86.2		
SO2	6954.0	87.7	5390	67.2	3055.0	38.0	7055.0	88.0	5385.0	67.1
PM10	6835.0	85.0	6853	85.4	6664.0	83.1	7510.0	94.0	7510.0	94.0
PM2.5	6835.0	85.0	6853	85.4	6664.0	83.1	7510.0	94.0	7510.0	94.0
O3	6810.0	85.0	6606	82.4	6417.0	80.0	7527.0	94.0		
Ажилласан цаг хувь	6869.3	85.9	6417.6	80.5	5133.2	64.0	7199.5	89.9	6801.7	85.0
Нийт	Суурин харуулуудын ажилласан цаг 81%									

3.8 Суурин харуулын сэлбэг хэрэгслийг худалдан авч, солих, ЦУОШГ-тай хамтран суурин харуулын хэмжилтийн багажнуудад хийн тохиргоо хийж, баталгаажуулна.

Олон улсын MNS ISO/IEC 17025:2018 стандартын дагуу магадлан итгэмжлэлд хамруулахаар 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Итгэмжлэлийн техникийн хорооны хурлаар орж Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын Агаарын чанар хяналтын лаборатори нь техникийн хорооны бүх гишүүдийн 100%-ийн саналаар олон улсын MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлагыг хангасан лаборатори гэж итгэмжлэгдэж 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр TL 176 дугаартай Итгэмжлэлийн гэрчилгээ авсан.

Зураг №12



Итгэмжлэлийн гэрчилгээ авсан байдал

Улаанбаатар хотын агаарын бохирдлын хэмжилт судалгааны зориулалттай лабораторийн барилгын зураг төслийн ажил боловсруулах шатандаа явагдаж байна.

Дээрх хэмжилтийн үйл ажиллагааг нэгтгэн 2023 онд шинээр лабораторийн барилга барихаар төлөвлөж байгаа бөгөөд нийслэлийн нутгийн захиргааны барилгын нүүлгэн шилжүүлэлттэй холбоотойгоор газрын байршил төлөвлөлтийг шинээр зохион байгуулах нөхцөл байдал үүссэн тул байгууллагын албан хэрэгцээнд Хан-Уул дүүргийн 4, 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт 500-1000 хүртэлх метр квадрат газрыг шийдвэрлэж өгөх хүсэлтээ Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд гаргаад байна.

3.9 "Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүс, түүнд мөрдөх журам"-ыг шинэчлэн тогтоож, сурталчлах ажлын хүрээнд:

Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62 дугаар тогтоолыг шинэчлэх саналыг НЗД-ын зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 5 дугаар хуралдаанд танилцуулсан. Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, Үүнтэй холбоотойгоор Агаарын чанарыг сайжруулах бүсэд Налайх дүүргийг нэмж, тус дүүргийн 1,2,3,4,5,6,7,8 дугаар хороодын гэр хорооллын 7,691 айл өрхийг хамруулах бэлтгэл ажлыг хангуулахаар Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлыг бууруулах асуудал хариуцсан орлогчийн 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 4 заалт бүхий 9 арга хэмжээ бүхий удирдамжийг батлуулж ажилласан, 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 01/2300 дугаар албан бичгээр холбогдох яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанд оруулж батлуулсан. "Агаарын чанарыг сайжруулах бүс, түүнд мөрдөх журам"-ыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлэн 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/424-А/1353 дугаартай Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан тушаал, захирамжийг батлуулсан. Тус тушаал захирамжаар Налайх

дүүрэг хамрагдаж 33 хяналтын ажилтан орчны бохирдлыг бууруулахад идэвхтэй оролцож, иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэн хяналт тавин хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Зураг №13



НИСЭЛЭЙН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС

2022.2023

Дүүрэг	1 дүгээр бүс (Харан)	2 дүгээр бүс (Харан)	3 дүгээр бүс (Харан)	4 дүгээр бүс (Харан)
Сонгинохайрхан	1, 2, 3, 4, 19, 20, 21, 22, 24, 25, 26, 27, 32, 33, 34, 35, 36, 38, 40, 41, 42, 43	5, 6, 7, 8, 9, 10, 11, 23, 28, 30, 31	-	12, 13, 14, 15, 16, 17, 18, 22, 29, 37
Баянзүрх	6, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 17, 18, 20, 22, 23, 24, 26, 27, 32, 33, 34, 35, 37, 38, 40, 41, 42	2, 21, 25, 27, 29	-	1, 3, 4, 5, 6, 7, 16, 19, 28, 31, 36, 40, 43
Чингэлтэй	17, 18, 19, 23, 24	7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16	-	1, 2, 3, 4, 5, 6
Сүхбаатар	9, 17, 18, 19, 20	11, 15, 16, 19	-	1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 10
Баянгол	8, 10, 11, 20, 21, 22, 23, 24	-	16	1, 2, 3, 4, 5, 6, 7, 9, 12, 13, 14, 16, 17, 18, 19, 24, 25, 26, 27, 28
Хан-Уул	4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 21, 22, 23	2	-	1, 2, 3, 10, 17, 18, 19, 20, 24, 29
Нарын	1, 3, 4, 5, 6, 7, 8	2	1	73
НИЙТ ХОРОО		197		
Тайлбар:	Түүхийн нүүрсийг үе шаттай хэрэглэнэ	Шалтгааны болон бусад их үүсвэрээр үе шаттай хэрэглэнэ	Бусад зарчмын хатуу түүхийн хэрэглэнэ	Бусад зарчмын хатуу түүхийн хэрэглэнэ

НИСЭЛЭЙН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮСЭД МЭРДӨХ ЖУРГАМ

1.1. Агаарын чанарыг сайжруулах бусад дараах стандартын шаардлага ханганаг түүх, зүүх, орчин үеийн их үүсвэр зарчмын түүх.

1.2.1. Агаарын чанарыг сайжруулах бусад дараах стандартын шаардлага ханганаг түүх, зүүх, орчин үеийн их үүсвэр зарчмын түүх.

1.2.2.1. Агаарын чанарыг сайжруулах бусад дараах стандартын шаардлага ханганаг түүх, зүүх, орчин үеийн их үүсвэр зарчмын түүх.

1.2.3.1. Агаарын чанарыг сайжруулах бусад дараах стандартын шаардлага ханганаг түүх, зүүх, орчин үеийн их үүсвэр зарчмын түүх.

1.2.4.1. Агаарын чанарыг сайжруулах бусад дараах стандартын шаардлага ханганаг түүх, зүүх, орчин үеийн их үүсвэр зарчмын түүх.

1.2.5.1. Агаарын чанарыг сайжруулах бусад дараах стандартын шаардлага ханганаг түүх, зүүх, орчин үеийн их үүсвэр зарчмын түүх.

1.2.6.1. Агаарын чанарыг сайжруулах бусад дараах стандартын шаардлага ханганаг түүх, зүүх, орчин үеийн их үүсвэр зарчмын түүх.

Засгийн газрын 2018 оны “Түүхийн нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62-р тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд сайжруулсан түлшний хэрэглээг нэвтрүүлсэн 4 дэх жилийн үр дүнг Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 15 цэгийн агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), PM_{2.5}, PM₁₀ тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O₃) болон цаг уурын үзүүлэлтүүдийг харуулуудын дүнгээр тодорхойлвол:

Улаанбаатар хотын 2022 оны хүйтний улирал 12 дугаар сарын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM_{2.5} тоосонцор 9 мкг/м³-ээр буюу 8 %-иар, PM₁₀ тоосонцор 32 мкг/м³-ээр буюу 19 %-иар, азотын давхар исэл (NO₂) нь 3 мкг/м³-ээр буюу 4 %-иар тус тус бага, харин хүхэрлэг хий (SO₂) нь 4 мкг/м³-ээр буюу 3 %-иар их байна.

Хүснэгт 1.

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS4585:2016	Дундаж агууламж /мкг/м ³ /			
		2018 оны 10-12-р сар, 2019 оны 1-4-р сарын дундаж /түүхийн нүүрс/	2020 оны 10-12-р сар, 2020 оны 1-4-р сарын дундаж /сайжруулсан түлш-1 дэх жил/	2021 оны 11 сарын байдлаар /сайжруулсан түлш-3 дахь жил/	2022 оны 12 сарын байдлаар /сайжруулсан түлш-4 дэх жил/
PM _{2.5} тоосонцор	50	107	64	65	103
PM ₁₀ тоосонцор	100	184	112	130	132

2022 оны 11 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцрын хэмжээ 1.2%-иар бага, PM10 тоосонцрын хэмжээ ижил түвшинд байна.

3.10 Сайжруулсан түлш нөөцлөх, түгээх, борлуулалтын цэгүүд бий болгож, үйл ажиллагааг жигдрүүлэх ажлын хүрээнд:

Монгол Улсын Засгийн газар, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороо, Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Хөрөнгө гаргах тухай” А/1023 дугаар захирамжаар 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах, нийслэлийн гэр хорооллын айл өрхийн хэрэглээнд зориулан сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлж ажиллахыг Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар, “Таван толгой түлш” ХХК-нд тус тус даалгасан. Захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Таван толгой түлш” ХХК, Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газартай хамтран 2022 оны 03 дугаар сараас эхлэн сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлэх боломжтой агуулахын судалгааг гаргаж нөөц бүрдүүлэлтийн ажлыг хэрэгжүүлсэн. 2022 оны бүтэн жилийн байдлаар нийслэлийн өмчийн 4 агуулахад 3,735 тонн, түрээсийн гэрээ байгуулан ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 55 агуулахад 96,265 тонн буюу нийт 100,000 тонн сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлэн өдөр тутам хяналт тавин ажиллаж байна. Нийслэлийн зүгээс 2022 онд сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлэх, агуулахын түрээсийн зардалд 3,2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан.

Хүснэгт 2.



НИЙСЛЭЛИЙН ТӨСВӨӨР БАРИГДСАН АГУУЛАХЫН ТҮЛШНИЙ НӨӨЦЛӨЛТ				
№	Хаяг	Талбайн хэмжээ	Агуулахын нэр	Нөөц
1	БЗД 21 дүгээр хороо тоосгоны задгай	1000	21-р бааз	1,195
2	СХД 4 дүгээр хороо Улаанчулуут	1000	Улаанчулуут	1,350
3	СХД 4 дүгээр хороо Үндэсний дата төв	1000	Үндэсний дата төв	Түүхий эд
4	ХУД 12 дугаар хороо Морингийн даваа	1000	Морин бааз	1,190
Нийт		4000		3,735

3.11 Сайжруулсан түлшний тээвэрлэлт

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1021 дүгээр захирамжаар нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд 2022-2023 онд сайжруулсан түлш тээвэрлэх гүйцэтгэгчийг хуулийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулан захиалагчийн хяналт тавьж ажиллахыг НАОБТГ болон “Таван толгой түлш” ХХК-нд даалгасан. Энэ ажлын хүрээнд газрын даргын 2022 оны А/04 дүгээр тушаалаар “Үнэлгээний хороо” байгуулан Төрийн болон орон нутгийн

өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-ээр нээлттэй зар тавин шаардлага хангаж материал ирүүлсэн **31** аж ахуйн нэгж байгууллагатай Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, НАОБТГ болон “Таван толгой түлш” ХХК нар хамтран нийслэлийн **7** дүүргийн гэр хорооллын **203,683** айл өрхийг сайжруулсан түлшээр хангах зорилгоор “Сайжруулсан шахмал түлш тээвэрлэх гэрээ”-г байгуулан ажилласан байна.

2022 онд Баянзүрх дүүрэгт-“Нью лакшури констракшн” ХХК, “Энхдэлгэр зам констракшн” ХХК, “Бага монгол импекс” ХХК, “Өнө эрдэс баялаг” ХХК, “Монгол спорт” ХХК, “Лэнгийн цагаан овоо” ХХК, “Хийморь эйч ар трак” ХХК, Баянгол дүүрэгт-“Эрдэнэс нар хур” ХХК, “Тэхилэн” ХХК, Сонгинохайрхан дүүрэгт-“Гранд авгуш” ХХК, “Тэгш бүр”д ХХК, “Өгөөдэй богд” ХХК, “Сейф транс” ХХК, “Хэнбуг трейдинг” ХХК, “Отгонбулаг” ХХК, “Ю би холболт” ХХК, “Өнө эрдэс баялаг” ХХК, “Цацрал зам хөгжил” ХХК, “Стар нест” ХХК, Сүхбаатар дүүрэгт-“Саммит бридж” ХХК, “Тэс менежмент” ХХК, “Кросс контри” ХХК, Хан-Уул дүүрэгт-“Завхан транс нэгдэл” ХХК, “Боб энерги констракшн” ХХК, “Мейжик тайм” ХХК, Чингэлтэй дүүрэгт-“Их эрхэтдеволепмент” ХХК, “Гранд даргилах транс” ХХК, “Ганжуур цамхаг” ХХК, “Мөнгөн дарь” ХХК, Налайх дүүрэгт-“Натурал грийн бридж” ХХК, “Батсуурь тэгш хүрээ” ХХК нийт **31** тээврийн компанийн **310** гаруй тээврийн хэрэгсэл, **600** гаруй ажилтнуудын хамтаар борлуулалтын цэгийн түлшний захиалга, агуулахын түлшний нөөцийн тээвэр, гэр хорооллын айл өрхийн хэрэглээний сайжруулсан шахмал түлшийг түргэн шуурхай хүргэх зорилгоор 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл **565,282** тонн түлшийг тээвэрлэж **14,1** тэрбум төгрөгийн санхүүжилтийг нийслэлээс олгон, хяналт тавин ажилласан байна.

Хүснэгт 3.

Ачилтын тайлан : 2022.01.01-12.05							
№	Дүүрэг	Өдөр 09:00-23:59 хооронд		Шөнө 00:00-09:00 хооронд		Нийт кг	
		Тоо	Жин кг	Тоо	Жин кг	Тоо	Жин кг
1	Сүхбаатар Дүүрэг	7211	44,626,725	1476	9,203,400	8687	53,396,125
2	Баянзүрх Дүүрэг	15828	100,135,050	4904	31,128,800	20732	128,263,850
3	Хан-Уул Дүүрэг	7587	51,717,300	1426	9,755,050	9013	61,472,350
4	Баянгол Дүүрэг	3852	27,525,650	1196	7,557,350	5048	35,083,000
5	Сонгино Хайрхан Дүүрэг	24907	160,986,175	5896	35,807,250	30803	193,793,425
6	Чингэлтэй Дүүрэг	10214	62,532,875	2700	16,976,400	12914	79,509,275
7	Налайх Дүүрэг	1878	11,517,050	401	2,247,000	2279	13,764,050
Нийт :		71477	459,040,825	17999	112,675,250	89437	565,282,075



Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1207 дугаар захирамжаар 2022 онд мөрдөгдөх сайжруулсан шахмал түлшний тээвэрлэлтийн тарифт нэмэлт өөрчлөлтийг оруулсан.

Нэр	2022 оны эхний хагас жил мөрдөгдөж байсан тариф /төг/	2022 сүүлийн хагас жилийн жил Одоо мөрдөгдөж байгаа тариф /төг/
Үйлдвэрээс агуулах	17,750	28,050
Үйлдвэрээс борлуулалтын цэг	35,500	28,050

3.12 Гэр хорооллын айл өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах “Нэг өрх-нэг карт” аян

Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Борлуулалтын урамшуулал олгох тухай” А/1022 дугаар захирамжийн хүрээнд тус газар нь сайжруулсан шахмал түлшний борлуулагч нарын борлуулалтын урамшуулал, борлуулалтын цэгийн өдөр тутмын түлшний татан авалтад хяналт тавьж ажиллахаар тусгагдсан. Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогчийн 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн баталсан удирдамжаар 2022-2023 онд ажиллах сайжруулсан шахмал түлшний борлуулалтын 650 борлуулалтын цэгийг сонгон шалгаруулж үе шаттай нээн ажиллуулж байна. 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 317,192.16 тонн сайжруулсан шахмал түлшийг дээрх 650 борлуулалтын цэгт тасралтгүй ханган нийлүүлж, борлуулалтын урамшууллын зардалд нийт 4,7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгон хяналт тавин ажиллаж байна.

Хүснэгт 4.

Баянгол	Баянзүрх	Сонгинохайрхан	Хан-Уул	Сүхбаатар	Чингэлтэй	Нд
30	160	222	52	63	93	30
БЦ тоо	650					

№	2022 Он/сар	1	2	3	4	5	9	10
		101,443	65,705	68,179	8,210	5,154	16,945	51,554

Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн ээлжит хуралдаанаар нийслэлийн хэрэглэгчдийг сайжруулсан түлшээр хангахад салбар хоорондын уялдаа холбоог шуурхай удирдлагаар хангаж ажиллах чиг үүрэг бүхий Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулсан. Энэ ажлын хүрээнд 2022 онд “Нэг өрх-нэг карт” зарчмынхаа хүрээнд хэрэгжиж буй эсэхэд Таван толгой түлш ХХК-ийн “Хэрэглэгчдэд үйлчлэх алба”-тай хамтран судалгаа хийж мэдээллийн зөрчил давхардлыг арилган сайжруулсан түлшний борлуулалтын цэгийн карт уншилтад хяналт тавьж, мэдээлэл өгч ажилласан.

Зураг №13



	НИЙТ КАРТ	ИДЭВХИТЭЙ	ХАЯСАН	УСТГАСАН
2022/01/01	303 297	250 376	52 921	
2022/06/30	301 000	199011	86989	15000

3.13 Агаарын чанарыг сайжруулах бүсийн зорилтот бүлгийн айл өрхийг сайжруулсан түлшээр хангах ажлын хүрээнд

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоол, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2019 оны “Үндэсний хорооны 2019 оны ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай” 19/20 дугаар тогтоол, Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны “Хөрөнгө гаргах, эрх шилжүүлэх тухай” А/805 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Зорилтот өрхийг сайжруулсан түлшээр хангах тухай” А/30, “Захирамжид өөрчлөлт оруулах тухай” А/1274 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаагаар 0-240 оноотой өрх болон байнга оршин суух хаягтаа амьдардаггүй шилжин суурьшигч өрх, өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдаагүй өрхөд сайжруулсан шахмал түлш олгох чиглэлийг холбогдох байгууллагуудад үүрэг болгосны дагуу тус ажлыг халаалтын улиралд хэрэгжүүлсэн. Нийслэлийн Агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагчаар батлуулсан 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Зорилтот бүлгийн айл өрхийг сайжруулсан шахмал түлшээр хангах” удирдамжаар агаарын чанарыг сайжруулах бүсэд өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны 240 онооноос доош оноотой өрхийг хамруулах зорилгоор “Таван толгой түлш” Нийслэлийн Нийгмийн халамжийн газартай хамтран 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд **175** борлуулалтын цэгээр дамжуулан **6,098** өрхөд тус бүр 6 шуудай буюу **219,528** шуудай сайжруулсан түлш олгосон.

Хүснэгт 5.


№	Дүүргийн нэр	Хорооны тоо	Түлш олгох цэгийн тоо	Түлш авах өрхийн тоо	Нийт олгосон түлшний хэмжээ /шуудайгаар
1	Баянгол	8	12	749	26964
2	Баянзүрх	19	39	1,200	43200
3	Сонгинохайрхан	31	60	1,400	50400
4	Сүхбаатар	11	18	900	32400
5	Хан-Уул	12	21	949	34164
6	Чингэлтэй	13	25	900	32400
	Нийт	94	175	6,098	219,528

/Зорилтот өрхөд олгосон түлшний хэмжээг хүснэгтээр харуулав/

Зорилтот бүлгийн **6,098** өрхөд сайжруулсан түлш олгох ажилд НАБОТГ нь Нийслэлийн Нийгмийн халамжийн газар, Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Халамж

үйлчилгээний хэлтэс, Таван толгой түлш ХХК-ийн нийт **20** гаруй ажилтан албан хаагчид хяналт тавьж, санхүүгийн баримт болон хамрагдсан өрхийн хувийн хэргийг бүрдүүлэх, олголтын мэдээ гаргахад заавар, чиглэл өгч ажилласан.

Зураг №14



Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу агуулах худалдан авах ажлыг зохион байгуулахаар нээлттэй тендер зарлан сонгон шалгаруулалтыг хийж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн.

3.15 Сайжруулсан түлшний үйлдвэр, агуулах, хангамжийн бааз хариуцан ажиллах Диспетчерүүдийн өдөр тутмын хийж хэрэгжүүлж буй ажлын гүйцэтгэлд хяналт тавих, удирдлага арга зүйгээр хангах ажлын хүрээнд:

Сайжруулсан түлшний Баруун болон Зүүн бүсийн үйлдвэр, агуулах, хангамжийн бааз хариуцан ажилладаг 8 диспетчерийн өдөр тутмын ажлын гүйцэтгэл, тайлан төлөвлөгөөг хянан удирдлага арга зүйгээр ханган ажиллаж байна. Мөн **8** диспетчерт ажлын байранд ажиллах нөхцөлийг бүрдүүлж малгай, куртик, өмд иж бүрэн албаны нормын хувцасаар ханган нийгмийн асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна.

3.16 Сайжруулсан түлшний зүүн бүсийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийн уялдаа холбоог шалгах, аюулгүй ажиллагааг хангах зорилгоор хөндлөнгийн дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд:

Нийслэлийн Засаг даргын орлогчийн 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн баталсан удирдамжийн хүрээнд “Таван толгой түлш” ХХК-ийн Зүүн бүсийн үйлдвэрт хөндлөнгийн дүн шинжилгээ ажиллах ажлын хэсгийг “Монголрос цветмет” ТӨҮГ-тэй хамтран байгуулсан. Зүүн бүсийн үйлдвэр нь одоогийн байдлаар түр хугацаагаар зогсолт хийж урсгал засварын ажлыг эхлүүлсэн. “Таван толгой түлш” ХХК-ийн Зүүн бүсийн үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд сайжруулсан түлшний Зүүн бүсийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийн уялдаа холбоог нягтлан шалгах, аюулгүй ажиллагааг хангах, хөндлөнгийн дүн шинжилгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2-3 удаагийн уулзалт зохион байгуулсан.

Зураг №15



2022 оны 05 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга, хэлтсийн дарга, түлшний бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн, “Монголросцветмет” ТӨҮГ-ийн Хөгжлийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Үйлдвэрлэл, техник технологийн хэлтсийн механик инженер нар “Таван толгой түлш” ХХК-ийн Зүүн бүсийн үйлдвэрт 2 өдрийн турш ажилласан.

Зүүн бүсийн үйлдвэр хариуцсан инженер ажлын хэсгийн гишүүдэд үйлдвэрийн өргөтгөл, технологийн горим, түлш үйлдвэрлэх явцын процесс, хөрөнгө оруулалтын төсөв, 2022 онд хийж хэрэгжүүлэх гүйцэтгэх ажлын төлөвлөгөө болон цаашид тулгамдаж буй асуудлын талаар ажлын хэсгийн гишүүдэд танилцуулсан.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Зүүн бүсийн үйлдвэрийн 2022 оны ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан тус үйлдвэрт нэн шаардлагатай байгаа сайжруулсан түлшний хатаагч төхөөрөмжийг яаралтай нэвтрүүлэх, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөл хийх, технологийн шугамуудыг автоматжуулах зэрэг ажлыг эрчимжүүлэх, туршилтын судалгааны ажилд дүгнэлт хийж ажилласан.

Зураг №16



Үндсэн ажлын чиг үүргийн хүрээнд сайжруулсан түлшний үйлдвэр, агуулах, хангамжийн бааз хариуцан ажиллах диспетчерүүдийн өдөр тутмын хийж хэрэгжүүлж буй ажлын гүйцэтгэлд хяналт тавих хүрээнд 2022 онд 3-4 удаагийн уулзалт хурал зохион байгуулж, удирдлага арга зүйгээр ханган ажиллаж байна. Мөн 7 хоног тутам сайжруулсан түлшний агуулах хангамжийн баазуудын нөөцлөлтөд хяналт тавих, түлш ачилтын тайлан мэдээг гаргуулан авч, мэдээ мэдээлэл солилцон, тулгамдаж буй асуудлыг цаг тухай бүр шийдэж, арга хэмжээ авч ажиллаж байна.

Зураг №17




3.17 100кВт-аас дээш хүчин чадалтай халаалтын зууханд хяналт шалгалт хийж, магадлан итгэмжлэл хийх ажлын хүрээнд:

Агаар бохирдуулагч томоохон суурин эх үүсвэр ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, магадлан итгэмжлэх ажлын удирдамжийг Нийслэлийн Засаг даргын агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагчаар батлуулж, холбогдох байгууллагууд руу 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 1/438 тоот албан бичгээр хүргүүлэн 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус ажлын хүрээнд 100 кВт-аас дээш хүчин чадалтай зуух ашигладаг ААНБ-ын магадлан итгэмжлэх хяналт шалгалтын дүнгээр нийслэлийн 9 дүүрэгт **246** аж ахуйн нэгж байгууллагын **410** халаалтын зуух бүртгэгдэж, тоологдов.

2021 оны халаалтын улиралд **246** аж ахуйн нэгж байгууллагын **410** халаалтын зуух бүртгэсэн нь өмнөх онтой харьцуулахад **11,4** %-иар буурсан байна.

❖ 100 кВт-аас дээш хүчин чадалтай зуухны түлшний хэрэглээ



Нүүрсний хэрэглээг төрлөөр нь авч үзвэл дараах үр дүн гарсан байна. Иймд эдгээр ангилалд багтах хүчин чадалтай уурын болон усан халаалтын зуухны хэрэглэдэг нүүрсний төрөл, хэмжээг нарийн судлах зайлшгүй шаардлагатай.

Улаанбаатар хотын төвийн 9 дүүргийн хэмжээнд 100 кВт-аас дээш хүчин чадалтай уурын болон усан халаалтын зуух ашиглаж буй ААНБ-ууд 2021 онд нийтдээ **190,665 тн** түлш хэрэглэсэн байна. Эндээс сайжруулсан түлш **11,277 тн**, мидлинг **54,655 тн**, түүхий нүүрс **124,733 тн** тус тус хэрэглэсэн байна.

ААНБ-ын хэрэглэсэн нүүрсний хэрэглээ, дүүргээр, тонн-оор

Хүснэгт 6.

Үндсэн мэдээлэл		БЗД	БГД	БН	БХД	НД	СХД	СБД	ХУД	ЧД	Нийт төвийн 9 дүүргийн хэмжээнд
Зуухны үндсэн мэдээлэл	Байгууламжийн тоо	42	10	2	2	29	83	28	29	21	246
	Зуухны тоо	79	11	2	12	46	116	49	55	40	410
Түлшний хэмжээ	Сайжруулсан түлш	2,525	250	0	0	6	4,656	1030	2,360	450	11,277
	Мидлинг	1,865	6,730	0	0	150	42,238	2,460	912	300	54,655
	Түүхий нүүрс	35,703	0	416	10,325	8,260	17,312	23,550	22,811	6,356	124,733
	Нийт хэрэглээ	40,093	6,980	416	10,325	8,416	64,206	27,040	26,083	7,106	190,665

100 кВт-аас дээш хүчин чадалтай зуух ашигладаг ААНБ-ууд нийт **190,665** тн нүүрс ашиглаж байгааг дүүрэг тус бүрээр гаргасан.

Зураг №18



Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалаар батлагдсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл хийх журам”-ын дагуу агаар бохирдуулагч эх үүсвэрийн мэдээллийн санг шинэчилж, тайланг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 1/68 тоот албан бичгээр холбогдох дээд байгууллагад хүргүүлсэн.

“Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам”-ын дагуу агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийг дараах ангилалаар бүртгэж тоолсон. Үүнд:

- **Ердийн галлагаатай 3-15кВт хүртэл хүчин чадалтай зуух.** Үүнд айл өрхийн ахуйн хэрэглээний ердийн болон сайжруулсан зуух. 2021 оны 9 дүүргийн хэмжээнд 3-15кВт хүртэл хүчин чадалтай 163,742 зуух тоологдсоны 59.2% буюу 96,908 нь ердийн, 40.8% буюу 66,834 нь сайжруулсан зуух байна.

Хүснэгт 7.

Нийслэлийн дүүргээр	Нийт зуухны тоо	Хэрэглэсэн түлшний хэмжээ			
		Нүүрс,тн	Мод,м3	Сайжруулсан түлш, тн	Бусад
Баянзүрх	35,162	0	57,111.5	15,0781.1	614

Баянгол	7,446	0	2,780.29	35,740.8	2
Багануур	3,432	13,402	6,646	0	0
Багахангай	365	2,266	393.3	0	833.5
Налайх	7,691	44,431.3	13,168.7	1,898.6	215.7
Сонгинохайрхан	59,721	0	101,893.5	193,124.4	200
Сүхбаатар	11,717	0	19,724.96	56,174.9	149
Хан-Уул	17,090	0	29,996.9	57,212.04	719.8
